



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 422

Модот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2018 оны 86 дугаар тушаал, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн дүрмийн 3.3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дарга (Б.Адъяахүү)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ

55
Ерөнхий боловсролын сургуулийн захирлын
2025 онысарын өдрийн
А/..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга
Гишүүд

Б.Адъяахүү
Б.Отгончимэг
М.Өсөхцэнгэл
Д.Мөнхгэрэл

Нийгмийн ажилтан
Багш
Багш
Багш

Нарийн бичгийн дарга

Л.Ариунтунгалаг

Нягтлан бодогч